



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/100

Мандалговь

“Дөл БГМ” ХХК-тай гэрээ байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн А/72 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Зах зээл ба бэлчээр төсөл, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих Ажилчдын байрын засвар (Дундговь, Дэлгэрцогт сум) ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Дөл БГМ” ХХК-тай 44,500,000 (дөчин дөрвөн сая таван зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зураг, төсвийн дагуу Ажилчдын байрын засварын ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Дөл БГМ” ХХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Мөнхбаяр)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), Дэлгэрцогт сумын Засаг дарга (П.Цолмонбаатар), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060407